



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 261628 Цахим хаяг: ganbaatarm@audit.gov.mn Ашид баланс аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН
ЗАХИРАЛ Г.ЦОГГЭРЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/580
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний урлагийн их театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний урлагийн их театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдад урамшуулал давхардуулсан, илүү цагийн хөлс хавтгайруулан олгосон, бартерын үйлчилгээгээр авсан хөрөнгө, бараа материалыг орлогод авч, бүртгэлд тусгаагүй зэрэг нийт 179,755.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 41,431.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “үнэлгээ ба хуваарилалт”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндэсний урлагийн их театр нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, улс, орны хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг урт болон дунд хугацаанд төлөвлөж чиг үүргийнхээ хүрээнд байгууллагын удирдлага зохион байгуулалт, урын сан, маркетинг, хүний нөөц, төр, хувийн хэвшил, олон нийтийн түншлэлийг хөгжүүлж төлөвлөлт, хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар 2020-2023 онд хэрэгжих Үндэсний урлагийн их театрын шинээр баригдах 49500 м2 талбайтай, 2500 суудалтай хүний их танхим, 1500 хүний суудалтай дуулалт жүжгийн танхим, 800 суудал бүхий хөгжмийн танхимтай театрын төслийн явц 10 хувьтай, тайлант онд эскиз зураг хийх ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Үндэсний урлагийн их театрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг, 4 зорилт, 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,737,420,771.99	1,883,004,586.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,000.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	-	10,000.00
31210	Төгрөг	-	10,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	10,000.00
33	АВЛАГА	2,540,353.78	26,237,638.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	507,715.68	-
33500	Бусад авлага	2,032,638.10	26,237,638.10
33510	Байгууллагаас авах авлага	-	24,205,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,032,638.10	2,032,638.10
35	БАРАА МАТЕРИАЛ	1,734,880,418.21	1,856,756,948.33
35100	Түүхий эд материал	1,557,516,162.98	-
35110	Тусгай зориулалттай материал	1,557,516,162.98	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,780,383.93	1,142,229.00
35400	Хангамжийн материал	173,583,871.30	1,855,614,719.33
35410	Бичиг хэргийн материал	2,094,365.00	1,462,786.00
35420	Аж ахуйн материал	165,249,506.30	133,828,038.20
35440	Түлш шатах тослох материал	6,240,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	1,720,323,895.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,606,815,368.64	1,436,893,786.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,606,815,368.64	1,436,893,786.97
39200	Биет хөрөнгө	641,467,297.03	471,858,215.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	457,053,729.62	454,353,729.62
39204	Хуримтлагдсан элэгдэл	(239,648,911.30)	(296,678,276.98)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	331,590,431.11	357,544,391.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(123,293,245.95)	(164,827,024.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,468,998.29	143,639,698.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,886,252.19)	(97,484,839.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	408,633,072.19	441,292,792.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	(261,450,524.74)	(365,982,255.26)
39300	Биет бус хөрөнгө	965,348,071.61	965,035,571.57
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(442,708.39)	(755,208.43)
39303	Бусад биет бус хөрөнгө	964,540,780.00	964,540,780.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,344,236,140.63	3,319,898,373.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,755,097.82
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,755,097.82
41300	Өглөг	-	2,755,097.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,686,047.82
41360	Бусад өглөг	-	69,050.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	69,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,344,236,140.63	3,317,143,275.58
51	Засгийн газрын хувь оролцоо	3,344,236,140.63	3,317,143,275.58
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,565,541,435.43	1,565,541,435.43
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,565,541,435.43	1,565,541,435.43
51200	Хуримтлагдсан үр дүн	1,763,206,755.20	1,736,113,890.15
51210	Өмнөх үеийн үр дүн	1,763,206,755.20	1,764,006,755.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	(27,892,865.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,487,950.00	15,487,950.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,344,236,140.63	3,319,898,373.40

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,266,434,281.00	6,601,088,825.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,400,000.00	1,835,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,400,000.00	1,835,550.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,400,000.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,835,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,835,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,260,034,281.00	6,599,253,275.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,130,852,300.00	4,586,074,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,130,852,300.00	4,586,074,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,129,181,981.00	2,013,179,075.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	440,089,021.00	923,253,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	689,092,960.00	1,089,925,175.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,143,143,283.03	6,627,294,190.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,143,143,283.03	6,627,294,190.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,688,105,258.03	5,970,694,973.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,603,147,359.58	3,677,914,225.23
210101	Үндсэн цалин	1,736,790,983.15	2,237,758,078.8
210102	Нэмэгдэл	398,744,548.52	713,198,186.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	217,287,529.90	300,431,482.93
210104	Урамшуулал	249,010,219.01	426,526,476.75
210105	Гэрээт ажлын хөлс	1,314,079.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,384,743.84	460,157,108.18
210201	Тэтгэврийн даатгал	223,870,598.22	312,958,716.65
210202	Тэтгэмжийн даатгал	24,307,485.40	36,799,599.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,878,372.05	29,439,693.43
210204	Ажилгүйдлийн даатгал	4,949,470.22	7,359,899.10
210205	Эрүүл мэндийн даатгал	50,378,817.95	73,599,199.94
2104	Хангамж, бараа материалын зардал	19,139,892.66	98,960,141.39
210401	Бичиг хэрэг	2,249,021.00	3,859,659.00
210402	Тээвэр, шатахуун	6,700,000.00	6,240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,253.66	47,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,618.00	18,714,364.10
210408	Бараа материал акталсны зардал	-	70,098,918.29
2105	Нормативд зардал	515,467.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	515,467.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,674,200.00	95,632,209.00
210604	Урсгал засвар	2,674,200.00	95,632,209.00
2107	Томилолт, зочны зардал	25,600,000.00	29,021,013.00
210702	Дотоод албан томилолт	-	29,021,013.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,642,412.68	1,336,595,775.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	549,681,806.13	1,327,253,907.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,400,000.00	8,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	283,300.00	88,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	398,152.00	193,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	462,300.00	226,500.00

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	20,306,854.55	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,001,182.27	272,414,501.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,552,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,001,182.27	269,862,501.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	455,038,025.00	656,599,216.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,837,862.00	644,437,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,204,900.00	68,700,365.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	413,632,962.00	575,737,435.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,200,163.00	12,161,416.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,801,763.00	12,161,416.24
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,398,400.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	123,290,997.97	26,205,365.05
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,687,500.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	1,687,500.00
5	НИЙТ ҮР ДҮН	123,290,997.97	(27,892,865.05)

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,261,964,071.30	6,599,693,825.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,929,790.30	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,929,790.30	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,929,790.30	-
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,929,790.30	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,260,034,281.00	6,599,693,825.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,130,852,300.00	4,586,074,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,130,852,300.00	4,586,074,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,129,181,981.00	2,013,619,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	440,089,021.00	923,253,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	689,092,960.00	1,090,365,725.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,139,595,121.30	6,498,855,405.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,139,595,121.30	6,498,855,405.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,684,557,096.30	5,890,572,688.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,603,862,008.04	3,674,882,778.41
210101	Үндсэн цалин	1,737,343,315.14	2,234,726,632.04
210102	Нэмэгдэл	398,906,864.99	713,198,186.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	217,287,529.90	300,431,482.93
210104	Урамшуулал	249,010,219.01	426,526,476.75
210105	Гэрээт ажлын хөлс	1,314,079.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,384,744.05	459,994,791.50
210201	Тэтгэврийн даатгал	223,870,598.22	312,796,399.97
210202	Тэтгэмжийн даатгал	24,307,485.40	36,799,599.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,878,372.05	29,439,693.43
210204	Ажилгүйдлийн даатгал	4,949,470.22	7,359,899.10
210205	Эрүүл мэндийн даатгал	50,378,818.16	73,599,199.94
2104	Хангамж, бараа материалын зардал	10,195,200.66	1,507,000.00
210401	Бичиг хэрэг	132,500.00	322,890.00
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	190,253.66	235,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,872,447.00	948,910.00
2105	Нормативд зардал	295,100.00	144,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	295,100.00	144,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,350,000.00	118,935,380.00
210602	Тавилга	-	10,091,280.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	18,844,100.00
210604	Урсгал засвар	3,350,000.00	90,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	25,600,000.00	29,021,013.00
210702	Дотоод албан томилолт	-	29,021,013.00
210701	Гадаад албан томилолт	25,600,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	714,870,043.55	1,557,770,625.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	689,309,437.00	1,548,428,757.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	8,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	283,300.00	88,760.00

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	398,152.00	193,608.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	462,300.00	226,500.00
210807	Газрын төлбөр	20,306,854.55	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	48,316,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	48,316,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	455,038,025.00	608,282,716.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,837,862.00	596,121,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,204,900.00	68,700,365.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	413,632,962.00	527,420,935.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,200,163.00	12,161,416.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,801,763.00	5,150,962.24
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,398,400.00	7,010,454.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	122,368,950.00	100,838,420.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	122,368,950.00	100,828,420.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	122,368,950.00	100,828,420.00
2200	Дотоод эх үүсвэрээр	122,368,950.00	100,828,420.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	122,368,950.00	100,828,420.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(122,368,950.00)	(100,828,420.00)
6	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	10,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,564,230,035.43	15,487,950.00	1,639,915,757.23	3,219,633,742.66
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,564,230,035.43	15,487,950.00	1,639,915,757.23	3,219,633,742.66
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,311,400.00	-	-	1,311,400.00
Тайлант үеийн үр дүн	-	-	123,290,997.97	123,290,997.97
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	1,763,206,755.20	3,344,236,140.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	800,000.00	800,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	1,764,006,755.20	3,345,036,140.63
Тайлант үеийн үр дүн	-	-	(27,892,865.05)	(27,892,865.05)
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,565,541,435.43	15,487,950.00	1,736,113,890.15	3,317,143,275.58

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,586,790,500.00	4,580,923,237.76	5,867,262.24	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	4,586,790,500.00	4,580,923,237.76	5,867,262.24	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,509,952,900.00	4,504,801,937.76	5,150,962.24	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,679,957,500.00	3,674,882,778.41	5,074,721.59	99.9
Үндсэн цалин	2,322,942,800.00	2,234,726,632.04	88,216,167.96	96.2
Нэмэгдэл	708,669,000.00	713,198,186.69	(4,529,186.69)	100.6
Унаа хоолны хөнгөлөлт	339,183,200.00	300,431,482.93	38,751,717.07	88.6
Урамшуулал	309,162,500.00	426,526,476.75	(117,363,976.75)	138.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	459,994,800.00	459,994,791.50	8.50	100.0
Тэтгэврийн даатгал	312,796,400.00	312,796,399.97	0.03	100.0
Тэтгэмжийн даатгал	36,799,600.00	36,799,599.06	0.94	100.0
ҮОМШӨ-ний даатгал	29,439,700.00	29,439,693.43	6.57	100.0
Ажилгүйдлийн даатгал	7,359,900.00	7,359,899.10	0.90	100.0
Эрүүл мэндийн даатгал	73,599,200.00	73,599,199.94	0.06	100.0
Хангамж, бараа материалын зардал	1,507,000.00	1,507,000.00	-	100.0
Бичиг хэрэг	102,500.00	322,890.00	(220,390.00)	315.0
Тээвэр, шатахуун	194,000.00	-	194,000.00	0.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	766,800.00	235,200.00	531,600.00	30.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	443,700.00	948,910.00	(505,210.00)	213.9
Нормативд зардал	144,600.00	144,600.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	144,600.00	144,600.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	128,844,100.00	128,844,100.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
Тавилга	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,844,100.00	18,844,100.00	-	100.0
Урсгал засвар	60,000,000.00	60,000,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,188,400.00	191,112,167.85	76,232.15	100.
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,922,800.00	188,922,799.85	0.15	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,647,500.00	1,647,500.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	138,800.00	88,760.00	50,040.00	63.9
Тээврийн хэрэгслийн татвар	198,400.00	193,608.00	4,792.00	97.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,400.00	33,000.00	21,400.00	60.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	226,500.00	226,500.00	-	100.0

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	48,316,500.00	48,316,500.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	48,316,500.00	48,316,500.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,837,600.00	76,121,300.00	716,300.00	99.1
Бусад урсгал шилжүүлэг	76,837,600.00	76,121,300.00	716,300.00	99.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,006,600.00	68,700,365.00	306,235.00	99.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,831,000.00	7,420,935.00	410,065.00	94.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,586,790,500.00	4,586,074,200.00	5,867,262.24	99.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,586,790,500.00	4,580,923,237.76	5,867,262.24	99.7
Улсын төсвөөс санхүүжих	4,586,790,500.00	4,580,923,237.76	5,867,262.24	99.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00	(10,000.00)	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	379.00	379.00	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	189	189	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	175	175	-	100.0
Үйлчлэх ажилтан	13	13	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	189	189	-	100.0

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,013,619,625.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	2,013,619,625.00
Бараа ажил, үйлчилгээний зардал	-	1,486,599,171.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	30,000,000.00
Томилолт, зочны зардал	-	29,021,013.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,427,578,158.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	527,010,454.00
Бусад урсгал шилжүүлэг	-	520,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	520,000,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,010,454.00
Улсын төсвөөс олгосон нэмэлт санхүүжилт, шилжүүлэг	-	7,010,454.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,013,619,625.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,013,619,625.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	923,253,900.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,090,365,725.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 179,755.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 138,324.3 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Цалинтай чөлөө олгосон нэр бүхий 7 ажилтанд 1,709.2 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт болон урамшуулал олгосон, Захирлын тушаалаар албан тушаалын цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны цалингаас 20 хувийн 99.9 мянган төгрөгийн суутгалыг хийгээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 6.4.2-т *"төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36,32 дугаар хамтарсан тушаалын 5.4-т *"Санхүүгийн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан тухайн албан хаагчийн сарын цалинг тооцож бодохдоо шийтгэлийг ногдуулсан шийдвэр гарсан өдрөөс шийтгэлийн хугацаа дуусах хүртэл хугацаанд тухайн албан хаагчийн цалинг шийтгэлд заасан хувиар бууруулан тооцож олгоно"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад хоол, унааны хөнгөлөлт болон урамшуулал илүү олгосон зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон

2. Тус байгууллагад бүртгэлтэй 4 автомашины нийт торгуулийг холбогдох албан хаагчдад хариуцуулж төлүүлж байх гэсэн зөрчлийг арилгаагүй, тайлант онд 2,552.0 мянган төгрөгийн торгуулийг байгууллагаас төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 6.4.2-т *"төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 *"аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнаар төлүүлээгүй төсвөөс төлсөн торгуулийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

1. Захирлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/72 дугаар тушаалаар 147 албан хаагч тус бүрд 24-56 цагийн илүү цагийн нэмэгдэл олгохоор тооцож, нийт 74,576.2 мянган төгрөг олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох" журмын 2 дугаар зүйлийн 3.3-т *"Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

2. Хамтран ажиллах гэрээний дагуу 2 байгууллагад урлаг соёлын үйлчилгээ үзүүлж бартераар авсан 21,084.9 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг орлогот авч, данс бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 *"Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ"* 23.5.3-т *"хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт"*

Үндэсний урлагийн их театрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

төвлөрүүлэх бусад орлого", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

3. Тоглолтын 79,183.3 мянган төгрөгийн орлогыг цахим и-баримтаар баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дагалдан болон туршилтын хугацаанд ажиллаж байгаа ажилтнуудад 550.3 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмын 1 дүгээр хавсралтын 2-т "Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтнуудад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгохдоо "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг баримтлан олгож байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 16 нэр төрлийн 147,845.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох талаар ТӨБЗГ-т санал хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд бүртгэх талаар байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7	Тоглолтын орлогыг и баримтаар баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	79,183.3			1	79,183.3						
8	Тус байгууллагын 4 автомашины 2,552.0 мянган төгрөгийн торгуулийг байгууллагаас төлсөн, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	2,552.0	1	2,552.0								
	Дүн	8	179,755.8	3	4,361.1	3	174,844.4	2	550.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 298.5 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст нийт 9,912,009.1 мянган төгрөгийн 227 мэдээлэл байршуулахаас 298,506.0 мянган төгрөгийн 16 мэдээллийг байршуулаагүй байна. Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	298,506.0	1	298,506.0		
	Дүн	1		1	298,506.0		